



АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ
ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2014 оны 08 сарын 24 өдөр

Дугаар А/156

Улаанбаатар хот

Хайгуулын тусгай зөвшөөрлийн дугаарыг
цахимаар олгох, өргөдөл хүлээн авах тухай

Засгийн газрын Агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Засгийн газрын 2017 оны 7 дугаар сарын 18-ны өдрийн "Өргөдлийн дугаарыг цахим хэлбэрээр олгох тухай" 210 дугаар тогтоол, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2017 оны 7 дугаар сарын 25-ны өдрийн А/160 дугаар тушаал, АМГТГ-ын даргын 2017 оны 7 дугаар сарын 27-ны өдрийн А/130 дугаар тушаалын 2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хайгуулын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийн дугаар олгох үйлчилгээний хөлс төлж бүртгүүлсэн аж ахуйн нэгжүүдэд 2017 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн 09 цаг 00 минутад өргөдлийн дугаарыг цахим системээр олгох ажлыг зохион байгуулсугай.

2. 2017 оны 8 дугаар сарын 29-ний өдрөөс эхлэн цахим өргөдлийн дугаар авсан аж ахуйн нэгжүүдийн хайгуулын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг олгосон дугаарын дагуу хүлээн авах ажлыг зохион байгуулахыг Кадастрын хэлтэс /Д.Мөнхтамир/-т даалгасугай.

3. Өргөдлийн дугаар олгох цахим системийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Эрдэс баялгийн мэдээллийн технологийн төв /Г.Золсайхан/-д даалгасугай.

ДАРГА

Б.БААТАРЦОГТ